

БАТЛАВ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.БАЯНБААТАР

**“СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД ОЛОН
УЛСЫН ХӨТӨЛБӨР” ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 01 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Нэг.Зорилго

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдэд хөгжилтэй орнуудын жишгээр олон талт хөгжлийг хангахуйц чанартай, боловсролын хэрэглэгдэхүүнээр тоглож суралцан, анхаарал, ой тогтоолт, бүтээлч байдал, шинжлэх ухаанч, математик сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх чадвар, хэл ярианы хөгжил зэрэг бүх талын хөрвөх чадваруудыг эзэмшүүлэхэд оршино.

Хоёр. Гүйцэтгэх ажлын даалгавар

- 2.1 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхэд захиалагчаар хянуулж, хүлээж авахыг зөвшөөрсөн тохиолдолд хүргэлтийг хийнэ.
- 2.2 Захиалагч байгууллагатай хэрэглэгдэхүүний чанар болон загварын талаар санал зөвшилцөж гүйцэтгэнэ.

Гурав: Төсөв

“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад олон улсын хөтөлбөр”

- Багц 1:** “МОНТЕССОРИ хөтөлбөр 8 цэцэрлэгт төсөвт өртөг: 64,800,000 төгрөг
- Багц 2:** STEAM хөтөлбөр 21 цэцэрлэгт төсөвт өртөг: 399,000,000 төгрөг
- Багц 3:** IM BRIEK хөтөлбөр 10 цэцэрлэгт төсөвт өртөг: 171,000,000 төгрөг

Дөрөв.Техникийн тодорхойлолт

№	Үйл ажиллагаа	Тайлбар
1	Хэрэглэгдэхүүний нэр:	Олон улсын хөтөлбөр (Олон улсын аюулгүй байдлын гэрчилгээ авсан, олон улсад хэрэглэгдэж буй хөтөлбөр)
2	Гарын авлага:	Багш, сурагчийн гарын авлага нь Монгол хэл дээр хэвлэгдсэн. Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, оюун ухааныг хөгжүүлэх, авьяасыг нээх, багаар болон ганцаарчилж ажиллах, математик хандлагад суурилан дизайн

		сэтгэлгээний мэдлэг, чадварыг хялбараар ойлгуулахад дэмжлэг болохуйц, ойлгомжтой байна. Мөн хүүхдийн мэдлэг, чадвар, дадал, хандлагыг төлөвшүүлэх, ахиц дэвшлийг хянах, дэмжин дүгнэх, сургалтын нарийвчилсан агуулгыг багтаасан байна.
3	Эрүүл ахуйн шаардлага:	Сурагчдын ой тогтоолт, өнгө ялгах чадварыг сайжруулж, өөрийгөө илэрхийлэх, нийгмийн харилцаа, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, эрүүл мэнд, биеийн тамирын хөдөлгөөн, гарын жижиг булчингуудыг хөгжүүлэхэд хүний биед хоргүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн материалаар хийгдсэн, хүүхдүүд амандаа хийж хазсан ч аюулгүй гадаргуйтай, чанарын шаардлагын тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй байна.
4	Хэмжээ:	Хүүхдүүдийн гарт тохируулан хамгийн багадаа 3,5 см-ээс дээш хэмжээтэй, шинжлэх ухааны олон төрлийн судалгаа, шинжилгээний ажил дээр үндэслэж бүтээсэн авьяас хөгжүүлэх үндсэн блок холбогчууд, шилжүүлэгч, чимэглэл, бусад
5	Зориулалт:	Хүүхдийн нас, хөгжилд нь тохирсон идэвх оролцоог нэмэгдүүлэх, амжилтыг өсгөх, мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, суралцах хүсэл тэмүүлэлтэй, хийж байгаа зүйлдээ хянамгай, оюуны хувьд эрүүл дадалтай хичээл, ном, дижитал контент тоглоом, дүрийн хөгжүүлэлтээр суралцахуйг дэмжих, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн модуль болон тоглоом хичээлийн хэрэглэгдэхүүнтэй байна.
6	Хэрэглэгч:	3-6 насны хүүхэд
7	Тоо, багц	Нэг бүлгийн хүүхдүүд багаар болон ганцаарчилж кабинетэд хичээллэж тоглонгоо суралцах, хөгжих боломжийг бүрдүүлсэн эд ангиудтай байна.
8	Гүйцэтгэгч:	Хэрэглэгдэхүүн нийлүүлсний дараа арга зүйн зааварчилгааг тухай бүр өгөх, сургагч багшийг ажиллуулах, сургалтын хэрэглэгдэхүүн дутах, эвдрэх, гэмтэхэд 2-5 хувийн нөхөн хангалтыг хийх, цаашид зах зээлийн үнээс хямд үнээр нийлүүлнэ.
9	Фото зураг:	Жишээ зураг болон түүнтэй дүйцэхүйц хэрэглэгдэхүүн байна.



ХЯНАСАН: БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  А.ОЧИР

БОЛОВСРУУЛСАН: МЭРГЭЖИЛТЭН  Б.ДУЛАМСҮРЭН